**Гэрээний дугаар № ХХЗХ/202112027**

**“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ БАЙНГЫН МОНИТОРИНГ ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭ ”**
Үзүүлэх

## Зөвлөх үйлчилгээний гэрээ

**Багц 1**
**“Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрт байнгын мониторинг хийх”**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

болон

**МАКСИМА МЕДИА ХХК-ИЙН**

хооронд байгуулсан гэрээ

**(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)**

**2021 он 03 сар 26 өдөр**

БАТЛАВ: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Г.ЧИНЗОРИГ /............................/
/гарын үсэг/

БАТЛАВ: "МАКСИМА МЕДИА" ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

З.ЭНХЖАРГАЛ/............................/
/гарын үсэг/

УЛААНБААТАР ХОТ МАКСИМА МЕДИА ХХК 1116229360 5533848

## "ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ МОНИТОРИНГ ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭ"

## ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Дугаар № 202112027/Багц-1

2021 оны 03-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү Үйлчилгээ үзүүлэх гэрээг нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо, түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга З.Эрдэнэчулуун /цаашид Захиалагч гэх/, Нөгөө талаас "Максима Медиа" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал З.Энхжаргал /цаашид Гүйцэтгэгч гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 03 сарын 30-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № 1-д тодорхойлсон "Ажлын даалгавар"-т заасан үйлчилгээг (цаашид "Үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.

2. Гүйцэтгэгч нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.

3. Захиалагч нь *Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт байнгын мониторинг хийх үйлчилгээний "Багц 1 - Улаанбаатар хотод үйл ажиллагааа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрт байнгын мониторинг хийх" ажлыг* (цаашид "ажил" гэх) ***221'133'000*** */хоёр зуун хорин нэгэн сая нэг зуун гучин гурван мянган/* (цаашид "гэрээний үнэ" гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн Гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт
- Хавсралт №1 Ажлын даалгавар
- Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь, бүтэц, загвар
- Хавсралт №3 Голлох мэргэжилтнүүдийн мэдээлэл
- Хавсралт №4 Мониторинг хийх үзүүлэлтүүд (хүснэгтээр үзүүлсэн байдал)
- Хавсралт №5 Тайлан хүргүүлэх хэлбэр, хугацаа
- Хавсралт № 6 Мониторинг-д хамрагдах телевизүүдийн жагсаалт
- Хавсралт №7 Төлбөрийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан Гүйцэтгэгч үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон цахим шуудан, утсан холбоогоор харилцана.

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| *З.Эрдэнэчулуун*<br>*Захиргаа Удирдлага Хамтын Ажиллагааны Газрын дарга*<br>*[Гарын үсэг]*________<br>ТАМГА<br><br>*А.Лувсан-Очир*<br>*Өргөн Нэвтрүүлгийн Зохицуулалтын Газрын дарга*<br>*[Гарын үсэг]*________<br>ТАМГА<br><br>*Н.Тогтохсүрэн*<br>*Зохицуулалтын Хэрэгжилтийн Хэлтсийн дарга*<br>*[Гарын үсэг]*________<br><br>Харилцаа холбооны зохицуулах хороо<br>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,<br>Сүхбаатарын гудамж-13,<br>Метро бизнес төв 5 давхар, 504 тоот өрөө<br>Утас: 304257, 304258 | *З.Энхжаргал*<br>*Максима Медиа ХХК-ийн гүйцэтгэх захирал*<br>*[Гарын үсэг]*________<br>ТАМГА<br><br>Максима Медиа ХХК<br>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,<br>Энхтайваны өргөн чөлөө-23,<br>UBH төв 13 давхар<br>77118887, 77116676<br>[Хас банк дахь 5000436771 тоот төгрөгийн данс] |